



**ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 1/267

Зуунмод

Г Тандалт шинжилгээний ажил Г
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6.2, 8.2.3, 14 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Малын бруцеллэз өвчинтэй тэмцэх стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэх зорилгоор бруцеллэз өвчинд мэдрэмтгий хээлтүүлэгч малд хийх тандалт шинжилгээний ажлыг 2023 оны 08 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн 2023 оны 08 дугаар сарын 23 буюу 10 хоногийн хугацаанд сумын хэмжээнд зохион байгуулсугай.

2.Сумын мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч (Г.Цэндсүрэн)-д ДААЛГАХ нь:

2.1.Бруцеллэз өвчний тандалт шинжилгээний ажлыг стандартын дагуу үр дүнтэй зохион байгуулах.

2.2.Малчин, мал бүхий иргэдийг бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх шинжилгээнд малаа бүрэн хамруулахын ач холбогдол, өвчний хор хөнөөлийн талаар ухуулан таниулах, ойлгуулах.

2.3.Дээж авах явцад дээжийн тээвэрлэлт, хадгалалтын хүйтэн хэлхээний горимыг алдагдуулахгүй байхад анхаарч, харанхуй, хуурай, зориулалтын байр, талбай, багаж хэрэгсэлд байлгах.

2.4.Шинжилгээнд хамрагдсан малыг таних шаардлагатай тул бүртгэл хийж, ялгаж болохуйц тэмдэг, тэмдэглэгээг хийх.

3.Хээлтүүлэгч малыг тандалт шинжилгээнд бүрэн хамруулж, малын эмч нарыг ажиллах нөхцөл боломжоор ханган, хүн хүчээр тусалж ажиллахыг сумын нийт малчин мал бүхий иргэдэд даалгасугай.

4.Мал эмнэлгийн улсын байцаагч (Б.Сарантуяа)-д ДААЛГАХ нь:

4.1.Тандалт шинжилгээний ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, шинжилгээнд малаа хамруулаагүй малчин, мал бүхий иргэдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллах.

4.2.Лабораторийн шинжилгээгээр эерэг буюу өвчтэй гарсан хээлтүүлэгч малыг үржилд ашиглахгүй байхыг онцгойлон анхаарч, өвчинтэй тэмцэх зааврын дагуу тодорхой арга хэмжээг хууль, дүрэмийн дагуу авч ажиллах.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Энхсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.САРАНГЭРЭЛ

